



БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 21001:2018

ТӨГСӨГЧИДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ҮЙЛ ЯВЦЫН УРСГАЛ ДИАГРАММ

БАЙГУУЛЛАГЫН НЭР	Монгол улсын их сургууль (МУИС)
БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ	Их сургуулийн гудамж – 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
БАРИМТ БИЧГИЙН №	NUM/EOMS/PFC/004
ХУВИЛБАР №	01
БОЛОВСРУУЛСАН ОГНОО:	2025-10-01

НЭГ.ЗОРИЛГО

1.1. Энэхүү журам нь МУИС-ийн төгсөгчидтэй холбоотой үйл ажиллагааны хүрээг тодорхойлох бөгөөд үүнээс гадна:

- 1.1.1. Төгсөгчдийг "МУИС"-ийн үйл ажиллагаанд тасралтгүй оролцохыг дэмжих замаар төгсөгч болон төгсөгчдийн холбоонд дэмжлэг үзүүлэх.
- 1.1.2. Төгсөгчдийн бүлэг, сүлжээг бий болгох, үйл ажиллагааг дэмжих
- 1.1.3. төгссөн мэргэжлийн болон бусад чиглэлээр гаргасан амжилтыг нь албан ёсоор хүлээн зөвшөөрч дотоод, гадаадад сурталчлан, өргөмжлөхөд оршино.

ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ


Журам нь МУИС -ийн бүх оюутнууд (төгссөн болон суралцаж байгаа), багш, ажилтнуудад хамаарна.

ГУРАВ.ХАРИУЦАХ

Оюутны хөгжлийн газар энэхүү журмыг хэрэгжүүлэх, ажил хэрэгч байх ажлыг бүхэлд нь хариуцна.

ДӨРӨВ.ҮЙЛ ЯВЦЫН УРСГАЛ БҮДҮҮВЧ

Төгсөгчидтэй хамтран ажиллах үе шат:



ТАВ.ТӨГСӨГЧИДТЭЙ ХАМТРАХ ҮЙЛ ЯВЦЫН ХАНДЛАГА

№	Үйл ажиллагааны үе шат	Норматив эшлэл	Хариуцагч
Төгсөгчдийн бүртгэл, мэдээллийг шинэчлэх			
1	Хөтөлбөрийг бүрэн дүүргэсэн бүх оюутны статусыг ERP (Enterprise Resource Planning) программ дээр оюутнаас төгсөгч болгон өөрчилнө. Оюутнаас төгсөгчдийн статусыг өөрчлөхийн тулд нэмэлт бүртгэл шаардлагагүй.	Төгсөгчдийн тайлан - ERP	ХЧБГ
2	Төгсөгчдийн дэлгэрэнгүй мэдээллийг 10/11-р сард тэнхим, багш нар, оюутнуудын нийгмийн сүлжээний профайл гэх мэтээс мэдээлэл авах замаар программ дээр хянаж, шинэчилнэ.	Төгсөгчдийн тайлан - ERP	Оюутны хөгжлийн газар / ERP админ
Төгсөгчдийн портал			
3	Төгсөгчдийн портал нь төгсөгчидтэй холбоотой мэдээллийн сан, үйл ажиллагааг удирдах боломж олгоно. Төгсөгч оюутны статус төгсөгч болж өөрчлөгдөхөд порталд хандах, ашиглах нөхцөл нь шинэчлэгдэнэ.	“Төгсөгчдийн холбоо” гарын авлага	Оюутны хөгжлийн газар ERP админ
4	Төгсөгч нь портал дээр байршсан төгсөгчийн үйлчилгээг ашиглахаар порталд бүртгүүлж болно.		
Бүлэг бүрдүүлэх			
5	Бусад хот, орон нутагт төгсөгчдийн бүлэг байгуулж болно. Төгсөгч оршин сууж байгаа газраасаа хамааран тэдгээр бүлэгт нэгдэх боломжтой. Ийм бүлгийн гишүүн төгсөгчдийн мэдээлэл Их сургуульд хадгалагдана.	Төгсөгчидтэй харилцах гарын авлага	ХЧБГ, Оюутны хөгжлийн газар
Төгсөгчдийн клуб			
6	Төгсөгчидтэйгөө илүү ойр харьцахын тулд “ББ нэр” төгсөгчдийн клуб байгуулна. Төгсөгч клубт элсэж, холбогдох үйл ажиллагаанд оролцох боломжтой.		Оюутны хөгжлийн газар
7	Төгсөгчдийн клубийн дүрэм, гол хариуцлагатай гишүүдийг сонгох зэрэг үйл ажиллагаа нь төгсөгчдийн клубийн гарын авлагад бичигдсэн байна. Гарын авлагыг портал дээр төгсөгчид үзэх боломжтой.		Оюутны хөгжлийн газар
Төгсөгчдийн бүтээлийн үзэсгэлэн			
8	Их сургууль төгсөгчдийн амжилтын замнал, ололт бүтээлийн талаар мэдэж байхын тулд мэдээллийн суваг бий болгосон байна. Whatsapp, LinkedIn, тэнхим, багш нараас авах гэх мэтээр төгсөгчдийн ажил, амжилтын талаар цуглуулсан мэдээллийг оюутны хөгжлийн газрын мэргэжилтэн шинэчилж байна.	Төгсөгчдийн бүтээлийн үзэсгэлэнгийн мэдээ	Маркетингийн ба Оюутны хөгжлийн газар
9	Оюутны хөгжлийн газрын мэргэжилтэн нь янз бүрийн эх сурвалжаас авсан мэдээллийг хянаж, амжилтын замнал / ололт бүтээлийг харуулах боломжтой төгсөгчийг тодорхойлно. Бүрэн дэлгэрэнгүй мэдээлэл / холбогдох бичиг баримтыг авахын тулд төгсөгчтэй холбоо барьж, бататгана.		
10	Төгсөгчдийн амжилтын замнал / ололт бүтээлийг брэнд, харилцааны сувгуудаар дамжуулан дотооддоо нийтэлнэ / мэдээлнэ. Мөн уг мэдээллийг их сургуулийн маркетингийн үйл ажиллагааны нэг хэсэг болгон сошиал медиа нийтлэлд ашиглана.		Оюутны хөгжлийн газар
Төгсөгчдийн сүлжээ, суралцах, хөгжих / арга хэмжээ			
11	Төгсөгчдөд зориулан цуглаан, суралцах, хөгжих зорилготой арга хэмжээ зохион байгуулна. Жилийн үйл ажиллагааны хуанлид төлөвлөсний дагуу арга хэмжээг бэлтгэж, зохион байгуулна.	Төгсөгчдөд зориулсан үйл ажиллагааны хуанли	Оюутны хөгжлийн газар

12	Бүх арга хэмжээний талаар бүх төгсөгчдөд э-майлаар мэдээлж байна.		Оюутны хөгжлийн газар
13	Арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө, эргэх холбоог хариуцагчийн хамт тодорхойлж, холбогдох багуудад мэдэгдэнэ.		Оюутны хөгжлийн газар
Төгсөгчийн үүр			
14	Тус их сургуулийн төгсөгчдийн харилцааг бэхжүүлэх зорилгоор сайн дурын оюутны нэгдэл болох төгсөгчдийн холбоог ректорын удирдлага дор байгуулдаг.		
15	Жил бүрийн төгсөгчдийн уулзалт, бүсийн оюутны уулзалт, нэр хүндтэй төгсөгчдийн кампус дахь лекц, төгсөгчдийн зөвлөх хөтөлбөр, жил тутмын товхимол зэрэг үйл ажиллагааг төгсөгчдийн холбоогоор зохион байгуулж, явуулдаг.		

ЗУРГАА.ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Энэ үйл явцад холбоотой эрсдэлийг тодорхойлж, баримтжуулан Эрсдэл ба боломжийн бүртгэлд тусгасан болно.

ДОЛОО.ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (KRIS)

№	ГТҮ-ийн тодорхойлолт

НАЙМ.ОРОЛТ/ГАРАЛТЫН МАТРИЦ

.... - оролт	Оролт	Үйл явц	Гаралт	Гаралтын холболт

ЕС.НОРМАТИВ ЭШЛЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Баримтын нэр	Баримтын №
1	Төгсөгчдийн тайлан - ERP	
2	Төгсөгчидтэй харилцах гарын авлага	
3	Төгсөгчдийн бүтээлийн үзэсгэлэнгийн мэдээ	
4	Төгсөгчдөд зориулсан үйл ажиллагааны хуанли	

АРАВ.МАЯГТЫН ЖАГСААЛТ

№	Бүртгэлийн нэр	Маягтын №
1		
2		

АРВАН НЭГ.ХЯНАЛТЫН ТҮҮХ, ЗӨВШӨӨРӨЛ

Хувилбар №	Өөрчлөлт	Хянасан огноо	Өөрчлөлтийн шалтгаан	Өөрчлөлт хийсэн	Өөрчлөлтийг баталсан
00	Эх хувь	xx.xx.xx	---	---	----